



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 596

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1, а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан нийт 629,007,003,651.90 (зургаан зуун хорин есөн тэрбум долоон сая гурван мянга зургаан зуун тавин нэгэн төгрөг өрэн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.3ам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн . 12 дугаар тогтоолын хавсралт

Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмж их нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хөрөнгийн үнэ (төгрөгөөр)
1	Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хатуу хучилттай авто зам	км	32.226	11,427,601,561.05	368,265,887,906.5
2	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн хатуу хучилттай авто зам	км	129.4	1,162,610,310.28	150,441,774,150.3
3	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	км	114	967,538,084.17	110,299,341,595.1
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		276 (хоёр зуун далан зургаа)		629,007,003,651.90 (зургаан зуун хорин есөн тэрбум долоон сая түрүүн мянга зургаан зуун тавин нэгэн төгрөг ерэн мөнгө)